



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

48090 Мандалговь, Сайнцагаан сум
Утас: 70592439, 70592208, 70593208
Е-мэйл: dundgovi@audit.gov.mn

БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
Т.ТӨРБАТ ТАНАА

2020.07.30 № 143
танай _____ -ны № _____ -т

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн Тэрбиш овогтой Төрбатын /ЗЮ77022033/ сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгийн хамт Төрийн аудитын байгууллагад ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцох бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050” болон холбогдох бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг шалгуур болгосон.

Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч Тэрбиш овогтой Төрбатын /ЗЮ77022033/ аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.


00120220366

Иргэн Тэрбиш овогтой Төрбатын /ЗЮ77022033/ мөрийн хөтөлбөр / хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Дундговь аймгийн сонгуулийн хороонд

Хавсралт хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ТӨВСАНАА